ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248 дугаарын утаснаас лавлана уу?
Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582
Ц.Саранчимэг- Ахлах аудитор
өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар

Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА ХУУДАС

- Аудит хийж дууссан тухай мэдэгдэл 2-3
- Танилцуулга ……. 4
- Санхүүгийн дотоод хяналт ……. 5
- Гол шийдлүүд ……. ……. 6
- Тайлбар мэдүүлгийн захидал……. 6
- Аудитын санал дүгнэлт ……. 6

Худалдан авах ажиллагааны албаны 2013 оны Санхүүгийн Тайланд аймгийн Аудитын газар аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Худалдан авах ажиллагааны 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд тус алба нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг, дотоод хяналт бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулбал:

1. Худалдан авах ажиллагааны албаны 2013 оны төсөв 39051.0 мянган төгрөгөөр батлагдаж нэмэлт 6400.1 мянган төгрөгийн төсөв нэмэгдэж 2013 оны сүүлээр сард төсвийн хуваарыг тодотгож 45451.1 мянган төгрөгөөр баталсан байна.
2. Үйл ажиллагааны орлого 7400.8 мянган төгрөгийн зардлыг гаргахдаа 29997 буюу төсөл хөтөлбөр гэсэн дансаар зарлага гаргаж Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 73 тоот тушаалаар батлагдсан журмын 2 дугаар хавсралтаарх Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 7.1 заалтыг зөрчин эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй энэхүү журмыг мөрдөж ажиллаагүй байна.
3. Бэлэн мөнгө гаргахдаа Мөнгөн кассын ажиллагааны журам зөрчин заасан дээд хязгаараас хэтрүүлэн 1000.0 мянган төгрөгийн бэлэн мөнгө гаргаж зарцуулсан нь төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3-д .. .

банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ... гэсэн заалтыг зөрчиж харилцах данстай өөрийн ажилтны холбогдох зардлыг бэлнээр гаргасан байна.

4. Албан томилолтын зардал 599,0 мянган төгрөгийг Сангийн сайдын 1992.02.20-ны өдрийн 39 тоот тушаалаар батлсан Албан томилолтын зардлын тухай журмыг мөрдөж ажиллаагүй үүнд томилолт олгосныг батлсан даргын гарын үсэг тамгагүй, томилолтоор ажилласан газрын тэмдэглэгээ ирсэн болон буцсан хугацааг огт бичээгүй, хэд хоног ажилласан нь тодорхойгүй байхад нягтлан бодогч нь бүрдэл болоогүй анхан шатны баримтаар гүйлгээ хийж зардлыг олгосон зөрчил илэрлээ.

Ерөнхий менежерээс аймгийн Аудитын газар тайлбар мэдүүлэг хүлээж байга**а** илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн дээрх дурьдагдсан алдаа зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага бичигдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

Ерөнхий Аудитор 2014 оны 3-р сарын 12-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Төв Аймгийн Аудитын Газар

Танилцуулга

1. Бид Худалдан авах ажиллагааны алба 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Худалдан авах ажиллагааны албаны даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Худалдан авах ажиллагааны алба нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
   - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах
   - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аймгийн Аудитын газар жилийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Худалдан авах ажиллагааны албаны удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар
Аймгийн худалдан авах ажиллагааны албаны дотоод хяналт шалгалть аудитыг зохион байгуулах журам батласан байна. Гэвч дотоод хяналтаар хийгдсэн ажил аудитын явцад ирээгүй болно.

2. Орлого,санхүүжилтийн талаар
Худалдан авах ажиллагааны алба нь тодотгосон төлөвлөгөөгөөр 45451.1 мянган төгрөг батлагдсан бөгөөд үүнийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлсэн байна. 2013 онд үйл ажиллагааны орлогоос тендерийн материалын үнэ 7000.0 мянган төгрөг, 2013 оны 06- дугаар сарын 14-нд Хот байгуулалт, барилга албанаас 90581.8 мянган төгрөг орж 2013 тухайн сарын 17-нд буюу 3 өдрийн дараа 85901.8 мянган төгрөгөөр зарлага гарч 4680.0 мянган төгрөг нь үлдэж нийт үйл ажиллагааны орлогоор 11030.0 мянган төгрөг орсон байна. Харилцахын журналыг сортлон шалгаж мөнгөн гүйлгээний тайлан тэнцэлд үнэн зөв тусгасан эсэхийг шалгахад санхүүжилт 7973.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Төсвийн сар, улирлын хуваарийг үзэж, хуваарийн дагуу санхүүжилтээ авсан эсэхийг Худалдан авах ажиллагааны албаны 2013 оны төсөв 39051.0 мянган төгрөгөөр батлагдаж нэмэлт 6400.1 мянган төгрөгийн төсөв нэмэгдэж 2013 оны сүүлээр сард төсвийн хуваарыг тодотгож 45451.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэхүү төсвийн хуваариар цалингийн зардлыг 7514,5 мянган төгрөгөөр бууруулж бараа ажил үйлчилгээний зардалыг 14741.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн ба энэ нь тавилга эд хогшил худалдан авах зардал дээр нэмэгдсэн байна.

3.Үндсэн хөрөнгө
2013 онд 15512.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авснаас 5530.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9212.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил , 770.0 мянган төгрөгийн программ хангамжийг орлогоор бүртгэж тайлагнасныг шалгахад аудитын

явцад 2601,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дутуу орлого авсныг нэмж тайланд тусгууллаа.
2013 оны 5 сараас эхлэн худалдан авсан үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байсныг аудитын явцад 767.7 мянган төгрөгийн элэгдлийг нэмж тооцуулж залруулга хийгдлээ.

4.Бараа материал

Бараа материалын тайлангаар 2700.9 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч, 97.4 мянган төгрөгийн зарлага гарч оны эцэст 2603.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй дут уу тайлагнасан байсныг аудитын явцад орлого 2291,1 мянган төгрөгөөр, зарлагыг 2266,9 мянган төгрөгөөр тус тус нэмж залруулсан . Бараа материалын тайлан гаргалтыг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй шаардах хуудасыг даргаар цохуулаагүй байхад эд хариуцагч зарлага гаргасан, нягтлан бодогч нь бараа материалын тайланг хянаж баталгаажуулаагүй байна.

5.Цалингийн талаар

Тус алба нь 4 орон тоогоор батлагдаж 2013 онд 3 орон тоогоор ажиллаж 2220.6 мянган төгрөгийн цалин , НДШимтгэлийн зардлыг хэмнэсэн байна. Цалингийн зардалд 3 орон тооны ажилтан цалинжихаас гадна 2 ажилтанд нягтлан бодогч болон няравын ажлыг хавсран гүйцэтгэсэнд 2264.9 мянган төгрөгийн цалин шимтгэл олгосон байна. Гэвч нягтлан бодогч нь харилцахын хуулгыг сар бүр боловсруулаагүй, материалын тооцоог бодсон акт үйлдээгүй байна.

6.Бараа үйлчилгээний зардал

Худалдан авах ажиллагааны алба нь өөрийн байргүй учир тогтмол зардал гардаггүй.

2013 онд бараа үйлчилгээний зардалд 22101.2 мянган төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 19977.6 мянган төгрөг зарцуулж 2123.6 мянган төгрөг хэмнэсэн байна. Эд хогшил худалдан авах зардал нь нийт зардлын 17147.8 мянган холбогдуулан ширээ сандал, техник тоног төхөөрөмж авсантай холбоотой байна.

7.Мөнгөн хөрөнгө

Тайланд оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй тайлагнасан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар 41107.0 мянган төгрөгийн орлого 41107.0 мянган төгрөгийн зарлагаар тайлагнасныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны орлого бууруулан 7400.8 мянган төгрөгөөр хасалт хийсэн , мөн оны эцсийн үлдэгдэлийн татан төвлөрүүлсэн 7973.2 мянган төгрөгөөр санхүүжилтээ шууд бууруулсан байна. Санхүүжилтээ болон орлого бууруулсан хэмжээгээр залруулах хийхээр болж мөнгөн гүйлгээний тайлангаар орлого 56481,1 мянган төгрөг, зарлага 56481,1 мянган төгрөгөөр тайлагнаж залруулсан байна. Үйл ажиллагааны орлого 7400.8 мянган төгрөгийн зардлыг гаргахдаа 29997 буюу төсөл хөтөлбөр гэсэн дансаар зарлага гаргаж Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 73 тоот тушаалаар батлагдсан журмын 2 дугаар хавсралтаарх Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 7.1 заалтыг зөрчин эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй энэхүү журмыг мөрдөж ажиллаагүй байна. Бэлэн мөнгө гаргахдаа Мөнгөн кассын ажиллагааны журам зөрчин заасан дээд хязгаараас хэтрүүлэн 1000.0 мянган төгрөгийн бэлэн мөнгө гаргаж зарцуулсан нь төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3-д .. . банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ... гэсэн заалтыг зөрчиж харилцах данстай өөрийн ажилтны холбогдох зардлыг бэлнээр гаргасан байна. Худалдан авах ажиллагааны газрын дарга Э.Амарсайханы БНСУ-д зорчиход 1000,0 мянган төгрөг бэлнээр өгснөөс онгоцны тиизний үнэнд 699,6 мянган төгрөг үлдэгдэл 300,4 мянган төгрөгийг тушаагаагүй байна.

Албан томилолтын зардал 599,0 мянган төгрөгийг Сангийн сайдын 1992.02.20-ны өдрийн 39 тоот тушаалаар баталсан Албан томилолтын зардлын тухай журмыг мөрдөж ажиллаагүй үүнд томилолт олгосныг баталсан даргын гарын үсэг тамгагүй, томилолтоор ажилласан газрын тэмдэглэгээ ирсэн болон буцсан хугацааг огт бичээгүй, хэд хоног ажилласан нь тодорхойгүй байхад нягтлан бодогч нь бүрдэл болоогүй анхан шатны баримтаар гүйлгээ хийж зардлыг олгосон зөрчил илэрлээ.

8.Авлага ,өглөгийн талаар

НДБайгууллагатай хийсэн тооцоог өглөгийн тайлангаар шалгахад НДХэлтэсийн тайлангаар 948.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй өглөгтэй байхад тус Худалдан авах ажиллагааны алба нь 71.2 мянган төгрөгийн өртэй гэж тайлагнасан байна. НДХэлтэст илүү төлсөн 948,5 мянган төгрөгийг төлүүлэхээр акт бичигдлээ.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

1. НДХэлтэст илүү төлсөн 948,5 мянган төгрөгийг төлүүлэхээр акт бичигдлээ.
2. Гадаад томилолтын урьдчилгааны үлдэгдэл 300,4 мянган төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэлээ.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандард нь аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн шинжээчийн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ байгууллагын даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн аудитын газраас ажлын баримтанд үндэслэн санхүүгийн тайланд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул **Зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар